



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/31

Булган сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, мөн хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг хавсралтад заагдсан сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт олгосугай.

2.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системээр 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж, гэрээ байгуулан хүлээн авахыг хавсралтад заагдсан сумдын Засаг дарга, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

4.Хавсралтад тусгагдсан төсөл арга хэмжээг холбогдох хууль, журмын дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРӨВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6395010055

Аймгийн Засаг даргын 2025 оны
... дүгээр сарын ...-ны/ний өдрийн ... дүгээр
захирамжийн хавсралт

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Нийт төсөвт өртөг /мян.төг/	Тухайн онд санхүүжүүлэх төсөвт өртөг /мян.төг/	ХАА-нд мөрдөх журам	Тайлан мэдээ ирүүлэх хугацаа	Эрх шилжүүлсэн сумын Засаг дарга
1	2	3	4	5	6	7
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-Агт сум)	100,000.00	100,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Баян-Агт сумын Засаг дарга Б.Бямбажав
2	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Гурванбулаг сум)	180,000.00	180,000.00	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Гурванбулаг сумын Засаг дарга Б.Дэлгэр
3	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бугат сум)	180,000.00	180,000.00	НТШ	Сар бүрийн 25-ны өдөр	Бугат сумын Засаг дарга Х.Ууганбаяр
4	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Тэшиг сум)	90,000.00	90,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Тэшиг сумын Засаг дарга Б.Гансүх
5	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бүрэгхангай сум)	90,000.00	90,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Бүрэгхангай сумын Засаг дарга Э.Эрдэнэбулган
6	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн засвар, тохижилт	10,000.00	10,000.00	ШХА	Сар бүрийн 25-ны өдөр	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Б.Ариунболд
7	ЕБСургуулийн сантехникийн засвар (Дашинчилэн сум)	30,000.00	30,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Дашинчилэн сумын Засаг дарга С.Мэнд-Амар
Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	ГХБХБГ-ын иргэдэд үйлчлэх түргэн үйлчилгээний киоск машин худалдан авах (1ш)	20,000.00	20,000.00	ШХА	Сар бүрийн 25-ны өдөр	ГХБХБГ-ын дарга Ү.Бямбасүрэн
2	Татварын газрын тоног төхөөрөмж	25,000.00	25,000.00	ХА	Сар бүрийн 25-ны өдөр	Татварын газрын дарга Д.Лхагвасүрэн
Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээ						
1	Хог дарж булах техник авах (Рашаант сум)	80,000.00	80,000.00	ХА		Рашаант сумын Засаг дарга Б.Жавзмаа
НИЙТ ДҮН		805,000.0	805,000.0			